



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/122

Сангиндалай

Мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8, дахь заалт, Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаал Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд гоц халдварт мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тов мэдээг малчид, мал бүхий иргэдэд хүргэн, бэлэн байдлыг хангуулж бог малыг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Малчид мал бүхий иргэдэд мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын мэдээлэл хүргэн бэлэн байдлыг хангуулж төлөвлөгөөт бог малыг бүрэн хамруулж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн Тархвар зүйч (Т.Машбат) нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг мал эмнэлгийн Тархвар зүйч (Т.Машбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ЛХАГВАМАНДАЛ

